

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 16-ны өдөр

Дугаар ...

БА-069/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1 давхар 1 блок түгээгчийн байр, зоорьгүй 1 давхар 1 блок харуулын байр, зоорьтой 2 давхар хөдөлгөөн удирдах төвийн барилга, 6.0м x 14.0м хэмжээтэй 2 аралтай түгээгүүрийн саравч, 25м³ 2 ширхэг нөөцийн сав бүхий шатахуун түгээх станцын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок агуулахын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок 110 (нэг зуун арав) автобусны дулаан гаражийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок угаах цех, кузов засварын барилга, зоорьгүй 2 давхар 1 блок засвар үйлчилгээний төвийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок зуухны барилга нийт 11 блок бүхий Нийтийн тээврийн автопаркийн зориулалттай барилга байгууламжид 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 16 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/04/08 огноо, 014752 дугаар, БАЗГ2024/0179;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар Шифр: РМ-19/2023, РМ-19/2023-01, РМ-19/2023-02, РМ-19/2023-03, РМ-19/2023-04, РМ-19/2023-05, РМ-19/2023-06, РМ-19/2023-06а, РМ-19/2023-07, РМ-19/2023-08, РМ-19/2023-09, ЭТ-18/2023;

2.3. Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ оноосон нэр, 9011122089 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2659603 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 23 дугаар хороо, Наадамчдын гудамж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор барилга Б блок, 11-327199 холбоо барих утас, www.ulaanbaatar.mn цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Улз Буянт Пропертиз ХХК оноосон нэр, 9011713113 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6263704 регистрийн дугаар, БУ12-199/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо, 13-р хороолол ХД-65, Улз гол цогцолбор, 95952222 холбоо барих утас, info@vipresidence.mn цахим хаяг;

УЛААНБААТАРЫН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Ричмон консалтинг ХХК оноосон нэр, 9011657112 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6159168 регистрийн дугаар, ЗТ11-412/22 зураг төслийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, москва, үйлдвэрийн бүс, 51/6, 88 тоот, 99104142 холбоо барих утас, solongo@rmc.mn цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ оноосон нэр, 9014001141 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 7037793 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Өөрийн байранд, 99002974 холбоо барих утас;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1 давхар 1 блок түгээгчийн байр, зоорьгүй 1 давхар 1 блок харуулын байр, зоорьтой 2 давхар хөдөлгөөн удирдах төвийн барилга, 6.0м х 14.0м хэмжээтэй 2 аралтай түгээгүүрийн саравч, 25м³ 2 ширхэг нөөцийн сав бүхий шатахуун түгээх станцын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок агуулахын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок 110 (нэг зуун арав) автобусны дулаан гаражийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок угаах цех, кузов засварын барилга, зоорьгүй 2 давхар 1 блок засвар үйлчилгээний төвийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок зуухны барилга нийт 11 блок бүхий Нийтийн тээврийн автопаркийн зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

ХЯН
Барилга б

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

с) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 32 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1 давхар 1 блок түгээгчийн байр, зоорьгүй 1 давхар 1 блок харуулын байр, зоорьтой 2 давхар хөдөлгөөн удирдах төвийн барилга, 6.0м x 14.0м хэмжээтэй 2 аралтай түгээгүүрийн саравч, 25м³ 2 ширхэг нөөцийн сав бүхий шатахуун түгээх станцын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок агуулахын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок 110 (нэг зуун арав) автобусны дулаан гаражийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок угаах цех, кузов засварын барилга, зоорьгүй 2 давхар 1 блок засвар үйлчилгээний төвийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок зуухны барилга, нийт 11 блок бүхий Нийтийн тээврийн автопаркийн зориулалттай Нийтийн тээврийн автопаркийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын захиалгатай, зоорьгүй 1 давхар 1 блок түгээгчийн байр, зоорьгүй 1 давхар 1 блок харуулын байр, зоорьтой 2 давхар хөдөлгөөн удирдах төвийн барилга, 6.0м x 14.0м хэмжээтэй 2 аралтай түгээгүүрийн саравч, 25м³ 2 ширхэг нөөцийн сав бүхий шатахуун түгээх станцын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок агуулахын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок 110 (нэг зуун арав) автобусны дулаан гаражийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок угаах цех, кузов засварын

АЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР
байгууламжийг ашиг
орлуулах комисс

барилга, зоорьгүй 2 давхар 1 блок засвар үйлчилгээний төвийн барилга, зоорьгүй
1 давхар 1 блок зуухны барилга бүхий Нийтийн тээврийн автопаркийн барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын
газар ОНӨААТҮГ-ын Барилга захиалагчийн
хэлтсийн дарга



(Б.Ганзориг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын
биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



ИН

лалтанд

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 1 БЛОК ТҮГЭЭГЧИЙН БАЙР, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 1 БЛОК ХАРУУЛЫН БАЙР, ЗООРЬТОЙ 2 ДАВХАР ХӨДӨЛГӨӨН УДИРДАХ ТӨВИЙН БАРИЛГА, 6.0М Х 14.0М ХЭМЖЭЭТЭЙ 2 АРАЛТАЙ ТҮГЭЭГҮҮРИЙН САРАВЧ, 25М3 2 ШИРХЭГ НӨӨЦИЙН САВ БҮХИЙ ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН БАРИЛГА, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 2 БЛОК АГУУЛАХЫН БАРИЛГА, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 2 БЛОК 110 (НЭГ ЗУУН АРАВ) АВТОБУСНЫ ДУЛААН ГАРАЖИЙН БАРИЛГА, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 1 БЛОК УГААХ ЦЕХ, КУЗОВ ЗАСВАРЫН БАРИЛГА, ЗООРЬГҮЙ 2 ДАВХАР 1 БЛОК ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАРИЛГА, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 1 БЛОК ЗУУХНЫ БАРИЛГА НИЙТ 11 БЛОК БҮХИЙ НИЙТИЙН ТЭЭВРИЙН АВТОПАРКИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

Улаанбаатар хот

2024 оны 11 дүгээр сарын 12

Хан-уул дүүргийн 10 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын захиалгатай, зорьгүй 1 давхар 1 блок түгээгчийн байр, зорьгүй 1 давхар 1 блок харуулын байр, зорьтой 2 давхар хөдөлгөөн удирдах төвийн барилга, 6.0м х 14.0м хэмжээтэй 2 аралтай түгээгүүрийн саравч, 25м3 2 ширхэг нөөцийн сав бүхий шатахуун түгээх станцын барилга, зорьгүй 1 давхар 2 блок агуулахын барилга, зорьгүй 1 давхар 2 блок 110 (нэг зуун арав) автобусны дулаан гаражийн барилга, зорьгүй 1 давхар 1 блок угаах цех, кузов засварын барилга, зорьгүй 2 давхар 1 блок засвар үйлчилгээний төвийн барилга, зорьгүй 1 давхар 1 блок зуухны барилга нийт 11 блок бүхий Нийтийн тээврийн автопаркийн барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр 13.00 цагт 16 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 17.00 цагт дуусав.

Хуралд:

- | | | |
|---|--|--------------|
| 1 | Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2 | Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч | Б.Шинэжаргал |
| 3 | Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн дарга, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | Б.Найрамдал |
| 4 | Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч | Э.Цогзолмаа |
| 5 | Хяналт шалгалтын газар, дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Газрын тос, хийн хяналтын улсын байцаагч | Ч.Ганхуяг |

6	Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер	Ц.Билигт
7	Ус сувгийн удирдах газар Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер	Д.Болормаа
8	Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар Сүлжээ төлөвлөлтийн хэлтсийн Мэргэжилтэн	Ц.Дагвадорж
9	Нийслэлийн Онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, Хошууч	Б.Даваасүрэн
10	Барилгын Хөгжлийн Төв ОНӨААТҮГ-ын Норм нормативын хэлтсийн мэргэжилтэн	О.Ундрах
11	Үндэсний төв архив, Ахлах архивч	Э.Шижиртуяа
12	Ашиглалт хариуцах байгууллага: Зорчигч тээвэр 4 ОНӨААТҮГ-ын захирал	С.Бямбасүрэн
13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан	Н.Эрдэнэтөгс
14	Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газрын Барилга захиалагчийн хэлтсийн бүс хариуцсан ахлах инженер	Б.Намсрайжав
15	Зураг төсөл зохиогч байгууллага: Ричмон консалтинг ХХК-ийн захирал	Ц.Мөнхболд
16	Гүйцэтгэгч байгууллага: Улз Буянт пропертиз ХХК-ийн захирал	Ц.Оюунчулуун

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 16
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 16

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-уул дүүргийн 10 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын захиалгатай, зоорьгүй 1 давхар 1 блок түгээгчийн байр, зоорьгүй 1 давхар 1 блок харуулын байр, зоорьтой 2 давхар хөдөлгөөн удирдах төвийн барилга, 6.0м x 14.0м хэмжээтэй 2 аралтай түгээгүүрийн саравч, 25м³ 2 ширхэг нөөцийн сав бүхий шатахуун түгээх станцын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок агуулахын барилга,

Барил

зоорьгүй 1 давхар 2 блок 110 (нэг зуун арав) автобусны дулаан гаражийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок угаах цех, кузов засварын барилга, зоорьгүй 2 давхар 1 блок засвар үйлчилгээний төвийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок зуухны барилга нийт 11 блок бүхий Нийтийн тээврийн автопаркийн барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Б.Шинэжаргал**:

- Барилгад ашигласан материалын тохиролын гэрчилгээ, Ил далд ажлын акт, Бетоны батбэхийн шинжилгээний бичиг, Улаан журнал БАЗГ шалгуулах
- Батлагдсан зураг төслийн дагуу барилга байгууламж Авто гаражийн металын карказын бэхэлгээ боолтыг хийж аюулгүй байдлыг хангах
- Зураг төсөл Зохиогчийн өөрчлөлтийн зураг төслийг шалгуулах,Тайлбар тодруулга ирүүлэх
- Зураг төсөл Зохиогч гишүүдийн ажил үүрэг, даалгаварын биелэлтийг хангуулж Зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг гаргаж ирүүлэх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн дарга, /Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч/ **Б.Найрамдал**:

- Зураг төсөлд газардуулагч зураг тусгах
- Гадна гэрэлтүүлэг хийх
- Түгээгүүрийн барилгын газардуулга шугам сүлжээний далд ажлын акт шалгуулах
- Хэмжилт туршилтын акт шалгуулах
- Гадна шугам сүлжээг ашиглалтад оруулснаар баталгаажуулах
- ШТС, ХС хаяг бирк тэмдэг тэмдэглэгээ хийх
- Гадна шугам сүлжээний батлагдсан зураг шалгуулах
- Ажил эхлүүлэх зөвшөөрөл шалгуулах

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**:

- Уурын зуухны тоног төхөөрөмж гадна дулаан хангамжийг Комисст хүлээлгэн өгөх
- Холигчийн насосны узелийг хаягжуулах
- Агаар сэлгэлтийн өгөх хэсгийн шугам хоолойг дулаалах
- Халаалтын коллектруудын торуудыг цэвэрлэж хаягжуулах

ХЯНАЛТ

а байгуу
оруу

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Газрын тос, хийн хяналтын улсын байцаагч **Ч.Ганхуяг:**

- Төслийн ерөнхий төлөвлөгөөний дагуу (46018:2013) ШТС-ын эдэлбэр газар дээр шаардлага хангасан гэрэлүүлэгтэй болгох
- Шатахууны сав, барилга байгууламж, тоног төхөөрөмжид худгийн ус орохооргүй болгох, засах
- Удирдлагын байрнаас цэнэглэх үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой байх
- Ерөнхий оруулга болон үйлчилгээний байрны шалны түвшинг буулгах болон түгээх талбайн түвшингээс өндөр түвшинд болгох
- Ослын улмаас шатахуун асгарсан тохиолдолд ШТС-ын эзэмшлийн газраас гадагш гаргахгүй байхаар төлөвлөсөн ба ШТС-ын зам талбайн орц гарц дээр 20см-аас багагүй өндөртэй байх
- Түгээгчийн байранд галын автомат төхөөрөмжтэй байх
- Эзэмшлийн талбай дах тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөн нь нэг чиглэлтэй байх орц гарчыг тодорхой болгох
- Галын сараатай байх, хэрэгслэлүүдийг байрлуулах
- Галын сарааны тэмдэг тэмдэглэгээг ил харагдахаар бичиж байрлуулах
- Аянга зайлуулагчийг хийж гүйцээх
- Саравч дээр тэмдэг тэмдэглэгээ бичих
- Түгээх талбай нь шатахууны үйлчлэлд тэсвэртэй, түүнийг хөрсөнд нэвчүүлэхгүй шинж чанар бүхий хийцтэй байхаар хийх
- Ашиглалтанд ормогц зөөврийн ШТС-ыг зөөх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ий техник хяналтын инженер **Ц.Билигт:**

- 2023.10.10-ны өдрийн 50/2023 дугаар техникийн нөхцөлийн дагуу хуваарилах байгууламж дэд өртөөг ашиглалтад оруулаагүй, УЭХ-д холбогдоогшй, эрчим хүчний тухай хуулийн 33, эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг тус тус зөрчсөн тул санал өгөхөөс татгалзав.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Д.Болормаа:**

- Батлагдсан цэвэр бохир усны ажлын зураг үзүүлэх:
 - Гадна цэвэр бохир усны далд ажлын акт бүрдүүлэх
 - Гадна шугам сүлжээг ХМС-д бүртгүүлэн актаар баталгаажуулах
- Гүний худгийн шугам дээр усны тоолуур суурилуулах
- Гүний худгийн битүүмж сайжруулах, дулаалга хийх
- Бохир ус зайлуулах трапны тунгаагуурт ус цэвэршүүлэх анхан шатны тоног төхөөрөмж суурилуулах
 - Мөн сараалж, тор, шүүр хийх, Элс тос баригч хийх

- Авто угаалгын цэвэр усны шугаманд усны тоолуур суурилуулах, диа32мм байх
- Засгийн газрын 73-р тогтоолыг хэрэгжүүлэх
- Гал тогооны тоноглолд стандартын дагуу тос баригч суурилуулах
- УСУГ-тай Гэрээ байгуулах
- Ундны усны нөөцийн саванд ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэн Актаар баталгаажуулах

Дээрх холбогдох бичиг баримт байхгүй, шугам сүлжээнд хяналт тавиулаагүй, гэрээгүй, зөвшөөрөлгүй бохир усны шугамд холбогдсон тул санал өгөхөөс татгалзаж байна.

Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХК-ий Удирдлага төлөвлөлтийн газрын Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Ц.Дагвадорж:**

- Галын дохиолол, хяналтын камерын системүүдийн нэгтгэлийг хийж бүрэн ажиллуулах
- Холбооны худгуудын кабелийг цэгцлэх, таг хүчүүвчийг бэхлэх
- Зарлан мэдээллэх системийг ажилуулах
- Худаг сувагчлалын угсралтын ажлыг Актаар хүлээлцэх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн Онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, хошууч **Б.Даваасүрэн:**

- Спринглер шалгасан Акт үзүүлэх
- Галын дохиоллын систем шалгасан Акт, фото зураг хавсаргах
- Гал унтраах анхан шатны багаж зэвсэглэл MNS5566:2020 стандартын дагуу баталгаажуулах
- Стандарт норм дүрмийн дагуу дутуу ажлаа хийж гүйцэтгэх
- Зөөврийн ШТС зөөх албан бичиг өгөх
- Дотуур даралтат усны цэг тотго комут солих, тэмдэглэгээ хийх, ус тавьж шалгах
- Авто зогсоолыг БНБД 21-05.10-н дагуу 5.23, 6.26-ын заалт дагуу хийх
- Гадна дулаалгын дүгнэлт, Ил далд ажлын акт, фото зураг үзүүлэх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Архивын ерөнхий газар, ахлах архивч **Э.Шижиртуяа:**

- Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, хуудас дугаарлах, дотоод товъёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивт хүлээлгэж өгөх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын Хөгжлийн Төв ОНӨААТҮГ-ын Норм нормативын хэлтсийн мэргэжилтэн **О.Ундрах:**

- Дулаан гаражийн Б дээврийн прогоны татуурга 7, 8-ийг бүрэн хийж дуусгах
- Метал багануудын анкерын давхар боолтон бэхэлгээг зураг төслийн дагуу хийх
- 2 гаражийн дээврийн усны хаялгыг зураг төслийн дагуу хийх
- 2 гаражийн барилгын зүрхэвч, бүс бетон хийсэн акт, фото зураг нөхөж үзүүлэх
- Консолын дулаалга хийсэн акт, фото зураг нөхөж үзүүлэх
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу гэрээ байгуулсан төсвийн хүрээнд норм нормативын төлбөрийг төлөх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллага **Н.Эрдэнэтөгс:**

- Гаднах явган хүний зам талбайд харааны бэрхшээлтэй иргэдийн хөтөч замыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хийх
- АЦӨ-д ХБИ-д зориулсан АЦӨ-ний доторх зай талбай болон угаалтуур суултуурыг стандартын дагуу тоноглон хийж гүйцэтгэх
- Эр эм душ-д тус бүр нэг L хэлбэрийн бариул суурилуулж өгөх
- Эр эм АЦӨ-ний угаалтуур суултуур шээлтүүрийг бүрэн тоноглох

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Зорчигч тээвэр 4 ОНӨААТҮГ-ын захирал **С.Бямбасүрэн:**

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газрын Барилга захиалагчийн хэлтсийн бүс хариуцсан ахлах инженер **Б.Намсрайжав:**

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч байгууллага: "Ричмон консалтинг ХХК"-ийн захирал **Ц.Мөнхболд:**

- Ажлын зураг төсөлд тусгасан дээврийн хашлага хаалт хийх
- Гадна шат довжооны хашлага хаалт гүйцээж хийх

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Улз Буянт пропертиз ХХК-ийн захирал **Ц.Оюунчулуун:**

Комиссын бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлт хангагдсаны дараа ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- БНБД-ийн дагуу зохиогч нэгдсэн дүгнэлтийг эцэслэн бичих
- Барилгын тухай хуулийн дагуу гүйцэтгэгч барилгад чанарын баталгаа гаргаж ирүүлэх
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-уул дүүргийн 10 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын захиалгатай, зоорьгүй 1 давхар 1 блок түгээгчийн байр, зоорьгүй 1 давхар 1 блок харуулын байр, зоорьтой 2 давхар хөдөлгөөн удирдах төвийн барилга, 6.0м x 14.0м хэмжээтэй 2 аралтай түгээгүүрийн саравч, 25м³ 2 ширхэг нөөцийн сав бүхий шатахуун түгээх станцын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок агуулахын барилга, зоорьгүй 1 давхар 2 блок 110 (нэг зуун арав) автобусны дулаан гаражийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок угаах цех, кузов засварын барилга, зоорьгүй 2 давхар 1 блок засвар үйлчилгээний төвийн барилга, зоорьгүй 1 давхар 1 блок зуухны барилга нийт 11 блок бүхий Нийтийн тээврийн автопаркийн барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:

Нийслэлийн хөрөнгө оруулалтын
газар ОНӨААТҮГ-ын
Барилга захиалагчийн хэлтсийн
дарга



(Б.Ганзориг)

